



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 03.15 № 3/449

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Оргил рашаан сувилал" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

"Оргил рашаан сувилал" ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

"Оргил рашаан сувилал" ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар "Оргил рашаан сувилал" ТӨХК-ийн санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Оргил рашаан сувилал" ТӨХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ДААЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ОРГИЛ РАШААН СУВИЛАЛ ТӨХК 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

*YAG –ын Санхүүгийн Аудитын Газрын
Дарга: Ц.Наранчимэг
Утас: 263533*

*Аудитын менежер : Я.Самбууням
Утас: 260512*

Аудитор: Ж.Болормаа

*Аудитор : “Координат Аудит” ХХК
Гүйцэтгэх захирал - П.Баярмаа
Утас : 99193732*

**Монгол улсын
Үндэсний аудитын газар**

Хаяг : Засгийн газрын IV байр,
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу – 6,
Улаанбаатар – 46, Монгол улс

Вэб хуудас: www.mnao.pmis.gov.mn

АУДИТЫН ТАЙЛАН

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн
Санхүүгийн тайлан

Хэвлэсэн огноо :
2017 оны 3 –р сарын 15

АГУУЛГА

1.	АУДИТ ХИЙХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ	1
2.	БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН	2
3.	БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА	2
4.	АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АУДИТЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, ХЯНАЛТЫН СОРИЛ БОЛОН НАРИЙВЧИЛСАН ГОРИМ, ТҮҮНИЙ ҮР ДҮН	3
5.	ДОТООД ХЯНАЛТ	3
6.	МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН	3
7.	ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР	3
8.	ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ	4
9.	ОЛЖ ТОГТООСОН ГОЛ ЭРСДЭЛҮҮД, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР	4
10.	ГОЛ, ОНЦЛОХ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР	4
11.	АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР	4
12.	ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР	5
13.	АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ.....	6
14.	ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД	6
15.	САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ.....	6
16.	ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	6
17.	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТОХИРОХ ЗАГВАРЫН ТАЛААРХ ДҮГНЭЛТ	6
18.	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	8
19.	АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	12

1. АУДИТ ХИЙХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 болон 18.2 –т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Оргил рашаан сувилал” ТӨХК –ийн 2016 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Монгол улсын Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Оргил рашаан сувилал” ТӨХК–ийн 2016 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, бодлого, журам” –ын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төрийн аудитын байгууллага нь тухайн байгууллагын санхүүгийн тайлангууд нь тус байгууллагын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/-ын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн эсэх талаар санал дүгнэлтээ илэрхийлэх үүрэгтэй.

“Оргил рашаан сувилал” ТӨХК –ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын ажлыг 2016 оны 12 дугаар сарын 22 –ний өдрөөс 2017 оны 03 дугаар сарын 10 –ны өдрийн хооронд гүйцэтгэхээр төлөвлөсний дагуу "Координат Аудит" ХХК –ийн аудитын баг гүйцэтгэв. “Оргил рашаан сувилал” ТӨХК –ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 3 дугаар сарын 07 –ны өдөр "Координат Аудит" ХХК –д ирүүлсэн байна.

"Координат Аудит" ХХК жилийн эцсийн аудитыг 2017 оны 3 дүгээр сарын 07 –ны өдрөөс 2017 оны 3 дугаар сарын 13–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 15 –ны өдөр “Оргил рашаан сувилал” ТӨХК–ийн удирдлагад гардуулна.

2. БАЙГУУЛЛАГЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

“Оргил рашаан сувилал” ТӨХК нь Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Рашааны тухай хууль, Нягтлан болох бүртгэлийн тухай хууль, Архивын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль шинэчлэгдэн 2016 оны 1 дүгээр сарын 1 –ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн. Мөн төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам Сангийн сайдын 2016 оны 4 дүгээр сарын 8 –ны өдрийн 131 дүгээр тушаалаар батлагдан, мөрдөгдөж эхэлсэн ба эдгээрээс бусад хууль, тогтоомж болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

3. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Оргил рашаан сувилал” ТӨХК –ийн эрхэм зорилго нь үйлчлүүлэгчдийн эрх ашгийг дээдлэн, байгалийн рашаан ус, эмчилгээний шавар ашиглан дорнын болон орчин үеийн анагаах ухааны эмчилгээний аргуудыг хослуулан эмчилгээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа олон улсын чанарын стандартын түвшинд хүргэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх замаар өрсөлдөх чадвараа дээшлүүлж, үр ашигтай ажиллахад оршино.

“Оргил рашаан сувилал” ТӨХК –ийн үйл ажиллагаа нь:

- Рашаан эмчилгээ – Оргил рашаан нь нүүрсхүчлийн хийтэй, сул хүчиллэг орчинтой, геохимийн исэлдэх төлөвтэй, гидрокарбонат, кальци-магнийн найрлагатай, сул эрдэсжилттэй, төмөр, цахиур, лити, стронци, цези, манган, цайр зэрэг биологийн идэвхит бичил элементүүдийг агуулсан хүйтэн рашаан юм.
- Шавар эмчилгээ – Өвчилсөн хэсэгт дулааны нөлөө үзүүлж судсыг тэлснээр тэр хэсгийн эд эсийн цусан хангамжийг сайжруулж, мэдрэлийн төгсгөлийн цэгт цочрол үзүүлснээр төв мэдрэлийн систем, вегетатив мэдрэлийн үйл ажиллагааг сэргээж бодисын солилцоог сайжруулан үрэвслийг дарж өвчин намдаана.
- Физик эмчилгээ – Өвчтөний биеийн байдал өвчний онцлогт тохируулан Электрофорез, УВЧ, Ультразвук, Улаан гэрэл, Амплипульс, Электросон Искра, Полюс, Поток, УФО зэрэг аппаратын 20 гаруй төрлийн эмчилгээ хийж байна.

Сувилалын цогц эмчилгээнд байгалийн рашаан ванн, эмчилгээний шавар, зүү төөнүүр, бариа засал, физик эмчилгээ, эмчилгээний гимнастик, усан шүршүүр, рашаан уух, сувилгааны хоол зэрэг эмийн бус эмчилгээ, засал зонхилдог бөгөөд клиник биохимийн лаборатори, оношийн кабинет ажиллуулдаг.

Сувилалд ихэвчлэн зүрх судасны, хоол боловсруулах эрхтний өвчин эмгэгтэй хүмүүсийг эмчлэх заалттай ба өвчнийг гүйцээн эмчлэх чиглэлээр цөсний хүүдий, хос гэдэсний шархлаа, зүрхний төрөлхийн болон олдмол гажиг, мөн түрүү булчирхай, бамбай булчирхайн мэс засал хийлгэсний дараах үе, зүрхний шигдээс өвчин, тархины цусан хангамжийн эмгэг өөрчлөлт зэрэг зайлшгүй шаардлагатай сэргээн засах эмчилгээ хийх 40 ортой клиникийн тасаг ажиллуулж байна.

“Оргил рашаан сувилал” ТӨХК -ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АУДИТЫН АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ, ХЯНАЛТЫН СОРИЛ БОЛОН НАРИЙВЧИЛСАН ГОРИМ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Оргил рашаан сувилал” ТӨХК -ийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 41-г гүйцэтгэв.

“Оргил рашаан сувилал” ТӨХК -ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Оргил рашаан сувилал” ТӨХК -ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Винаца санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

5. ДОТООД ХЯНАЛТ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Оргил рашаан сувилал” ТӨХК -ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд хэмжээний гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

6. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ТҮВШИН

Байгууллагын үйл ажиллагааны онцлог болон нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын үйл ажиллагааг судлан, шинжилсний үндсэн дээр тус байгууллагын 2016 оны тайлант санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг байдлын түвшинг “Орлогын дэлгэрэнгүй тайлан” дахь нийт орлогын дүнгийн 1 % хувиар тооцож, 28.1 сая төгрөгөөр тогтоолоо.

7. ОРЛОГО, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

2016 оны 1 дүгээр сард шинэ Төлөөлөн удирдах зөвлөл байгуулагдсан боловч Төлөөлөн удирдах зөвлөл хуралдах эрх зүйн боломж бүрдээгүй байсаар 2016 оны үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөө батлагдаагүй тул төлөвлөгөөний төслийг баримтлан үйл ажиллагаагаа явуулсан байна.

“Оргил рашаан сувилал” ТӨХК нь 2016 онд 3,219.6 сая төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөснөөс 2,801.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөөг 87.01 хувиар биелүүлсэн байна.

Нийт зардалд 3,133.3 сая төгрөг төлөвлөснөөс 2,797.7 сая төгрөгийн зардалтай ажиллаж, төлөвлөсөн зардлын төсвийг 335.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Тайлант хугацаанд Оргил рашаан сувилал нь 3.7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

8. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах талаар дараах ажил хийгдсэн байна. Үүнд:

2016 оны зорилтот түвшин, төсөв, төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө эрх бүхий байгууллагаар батлагдаагүйгээс шилэн дансны цахим хуудас www.shilendans.gov.mn –д мэдээллээ байршуулаагүй байна.

9. ОЛЖ ТОГТООСОН ГОЛ ЭРСДЭЛҮҮД, ТҮҮНИЙ ҮР ДАГАВАР

Аудитын төлөвлөгөөний дагуу 7 бүлэг эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс тус бүрээр нийт 41 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэлээ.

Худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгийг данснаас хасалт хийгээгүй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлээгүй, төлөгдөөгүй авлагыг бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчлүүд нь үнэлгээ ба хуваарилалт, бодитой оршин байх, тохиолдсон байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

10. ГОЛ, ОНЦЛОХ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААРХ ТАЙЛБАР

“Оргил рашаан сувилал” ТӨХК –ийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага өглөг, үндсэн хөрөнгө, орлого, цалин хөлс, элэгдлийн зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн шалгалаа. /ТАБ-СТА-А-5-3/.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 85.0 хувь, мөнгөн хөрөнгийн 95.0 хувь, нийт зардлын 88.0 хувь, нийт хөрөнгийн 95.0 хувийг тус тус эзэлж байна.

11. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад данс тус бүрээр материаллаг хэмжээний алдаа илрээгүй.

Аудитын явцад материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. 2016 оны 12 дугаар сарын 31 –ний байдлаар тус байгууллагын Санхүүгийн байдлын тайланд тайлагнагдсан үндсэн хөрөнгийн үлдэгдэлд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 157 нэрийн 276,330.7 мянган төгрөгийн анхны үнэ бүхий 1357 ширхэг хөрөнгө бүртгэгдэн, ашиглагдаж байгаа нь НББОУС16 –ын “Дахин үнэлгээний загвар” хэсэгт заасны дагуу дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг байгууллагын зүгээс зөвшөөрч, мөрдөж ажиллах талаар хариу ирүүлсэн.

2. Бараа материал худалдан авалтын анхан шатны баримтыг түүвэрлэн шалгахад, тамга тэмдгээр баталгаажуагүй, хүчин төгөлдөр бус баримтаар 15,579.6 мянган төгрөгийн, хувь хүний худалдан авалтанд өгсөн НӨАТ-ын цахим баримтаар 1,709.3 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/170 тоот захирамжаар “Татвар төлөгч иргэний баталгааны тэмдгийн загвар”-ыг баталсан бөгөөд тус баталгааны тэмдэгтэй хувь хүн, иргэдээс бараа худалдан авах гэдгийг зөрчиж байна.

Кассын зарлагын баримтыг түүвэрлэн шалгахад, анхан шатны баримтгүй 2,260.0 мянган төгрөгийн зардлыг бүртгэлд тусгасан нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” –ийн 7.7 Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг байгууллагын зүгээс зөвшөөрч, мөрдөж ажиллах талаар хариу ирүүлсэн.

3. Хувь хүмүүстэй ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан 9,310.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосноос ХХОАТ-ыг суутган авч, төсөвт төлөөгүй нь “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль” –ийн 26.1.1-д заасны дагуу татвар суутган, төсөвт шилжүүлэх гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өгснийг байгууллагын зүгээс зөвшөөрч, мөрдөж ажиллах талаар хариу ирүүлсэн.

12. ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДААНУУДЫН ТАЛААРХ ТАЙЛБАР

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй үлдсэн бусад алдааны талаар:

- Сангийн яамны 2016.04.20 –ны өдрийн 13-1/2443 тоот “Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх шилжсэн тухай” мэдэгдэлд “Рашаан савлах байр, байрны өргөтгөлийн барилга болох 85.6 сая төгрөгийн анхны өртөгтэй, 41.7 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үл хөдлөх хөрөнгийг “Хан Рашаан” ХХК –д 292.8 сая төгрөгөөр худалдан Сангийн Сайдын 2016 оны 134 дүгээр тушаалаар тус компанид өмчлөх эрхийг шилжүүлэн, 2016.04.11 –ний өдөр өмчлөх эрхийн 00546 тоот гэрчилгээг олгосон тухай “ мэдэгдсэн боловч тус хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас “Хан рашаан” ХХК -д худалдсан Рашаан савлах байрны хувьчлалын асуудлыг дахин шалгах ажлын хэсэг байгуулагдан, шалгаж байгаа тул данснаас хасч болохгүй, шалгалтын дараа хасах эсэхийг шийдвэрлэнэ гэж үүрэг өгсөн тул данснаас хасаагүй байна.
- Монгол Солонгосын Дорнын Анагаах Ухааны Төв нь тус компанийн 275.85 м2 талбай бүхий байрыг түрээслэн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд түрээсийн гэрээний хугацаа 2015.01.02-ны өдрөөр дуусвар болсон боловч гэрээ сунгагдаагүй. Мөн тус төв нь 2014-2016 он дуусталх хугацааны 55.8 сая төгрөгийн ашиглалтын зардлыг

төлөөгүй ба авлагаар бүртгэлд тусгаагүй байна. Энэ асуудал нь маргаантай байгаа бөгөөд шүүхийн шийдвэр яаж гарахаас хамаарч данс бүртгэлд тусгана гэсэн хүлээлттэй байна.

13. АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоол, 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Төрийн өмчийн хорооны 2015 оны 607 дугаар тогтоолоор "Оргил рашаан сувилал" ТӨХК –ийг үндсэн үйл ажиллагааны чиглэлийг нь өөрчлөхгүй байх нөхцөлтэйгөөр нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн байна.

14. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

“Оргил рашаан сувилал” ТӨХК –ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж, мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй.

15. САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

“Оргил рашаан сувилал” ТӨХК –ийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 19,5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба үүнд зохих заавар, зөвлөмж өгөн гарсан алдаа зөрчлийг шийдвэрлэхээр тохиролцсон.

16. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Координат Аудит” ХХК –аас тус байгууллагад 2 зөвлөмж өгснийг дараах байдлаар хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

- Тайлант хугацаанд худалдан авсан 4.6 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийн шинжтэй зүйлсийг бараа материалын БҮТЭЗ –ийн дансанд бүртгэн, тус данснаас ашиглалтанд тавьж олгосныг залруулан үндсэн хөрөнгөөр бүртгэлд тусгасан.

- Тайлант онд хамаарагдах төлбөр нь төлөгдөөгүй 4.7 сая төгрөгийн түрээсийн орлогыг авлагаар бүртгээгүй, түрээсийн орлогоос ТӨХ –нд төлөх 2.3 сая төгрөгийн өглөгийг бүртгэлд дутуу тусгасан байсныг 2016 оны 1 –р улиралд залруулсан.

17. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТОХИРОХ ЗАГВАРЫН ТАЛААРХ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй санал дүгнэлт

“Оргил рашаан сувилал” ТӨХК –ийн 2016 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлангуудад тус байгууллагын уг өдрөөрх санхүүгийн байдал хийгээд уг өдрөөр тасалбар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС,

түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, заавар журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.





YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ОРГИЛ РАШААН СУВИЛАЛ ТӨХК
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1: Үндсэн хөрөнгийн
үнэлгээний талаар

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2: Анхан шатны баримт
бүрдүүлэлтийн талаар

Асуудал 3: Хувь хүний орлогын албан
татварын талаар

18. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Оргил рашаан сувилал” ТӨХК -ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС –ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Энэ нь “Оргил рашаан сувилал” ТӨХК -ийн хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Оргил рашаан сувилал” ТӨХК -ийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Үндсэн хөрөнгийн үнэлгээний талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
<u>Ажиглалт:</u> 2016 оны 12 дугаар сарын 31 –ний байдлаар тус байгууллагын Санхүүгийн байдлын тайланд тайлагнагдсан үндсэн хөрөнгийн үлдэгдэлд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 157 нэрийн 276,330.7 мянган төгрөгийн анхны үнэ бүхий 1357 ширхэг хөрөнгө бүртгэгдэн, ашиглагдаж байна. Энэ нь НББОУС16 –ын “Дахин үнэлгээний загвар” хэсэгт заасны дагуу дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх гэж заасныг зөрчиж байна.	<u>Зөвлөмж:</u> Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийх тухай асуудлыг харъяа яамандаа мэдэгдэж, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх.
<u>Эрсдэлүүд:</u> Санхүүгийн тайлан бэлтгэх НББОУС тууштай мөрдөгдөхгүйгээс санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх.	<u>Үйлчлүүлэгчийн хариу:</u> 2016 оны 6-7 сард Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогоор үлдэгдэл өртөггүй болсон цаашид ашиглах боломжгүй 54 нэр төрлийн 57572.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлуулах саналаа Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлээд байгаа бөгөөд одоо хүртэл шийдвэрлээгүй байна. Мөн 2016 оны жилийн эцсийн тооллогоор ашиглалтын хугацаа дуусаж үлдэгдэл өртөггүй болсон үндсэн хөрөнгийн жагсаалтыг гаргаж ТӨБЗохигцуулалтын газарт хүргүүлэх бэлтгэл ажил хийгдэж байгаа болно.

Асуудал 2: Анхан шатны баримт бүрдүүлэлтийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
<u>Ажиглалт:</u> Бараа материал худалдан авалтын анхан шатны баримтыг түүвэрлэн шалгахад, тамга тэмдгээр баталгаажуулахгүй, хүчин төгөлдөр бус баримтаар 15,579.6 мянган төгрөгийн, хувь хүний худалдан авалтанд өгсөн НӨАТ-ын цахим баримтаар 1,709.3 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/170 тоот захирамжаар “Татвар төлөгч иргэний баталгааны тэмдгийн загвар”-ыг баталсан бөгөөд тус баталгааны тэмдэгтэй хувь хүн, иргэдээс бараа худалдан авах гэдгийг зөрчиж байна. Кассын зарлагын баримтыг түүвэрлэн шалгахад, анхан шатны баримтгүй 2,260.0 мянган төгрөгийн зардлыг бүртгэлд тусгасан нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль” –ийн 7.7 Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтыг зөрчиж байна.	<u>Зөвлөмж:</u> Холбогдох хууль тогтоомж, захирамжийг дагаж мөрдөх.
<u>Эрсдэлүүд:</u> • Татварын шалгалтаар акт торгууль ногдох • Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;	<u>Үйлчлүүлэгчийн хариу:</u> Зөвлөмжийг хүлээн авч цаашдын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах болно.

Асуудал 3: Үндсэн хөрөнгийн бүртгэл, хяналтын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
<u>Ажиглалт:</u> Хувь хүмүүстэй ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан 9,310.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосноос ХХОАТ-ыг суутган авч, төсөвт төлөөгүй нь “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль” –ийн 26.1.1-д заасны дагуу татвар суутган, төсөвт шилжүүлэх гэсэн заалтыг зөрчиж байна.	<u>Зөвлөмж:</u> Холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх.
<u>Эрсдэлүүд:</u> Татварын шалгалтаар акт торгууль ногдох, Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.	<u>Үйлчлүүлэгчийн хариу:</u> Цаашид хувь хүмүүсээс худалдан авалт хийсэн, ажил үйлчилгээ хийлгэсэн нөхцөлд ХХОАТатварийг суутган тооцож, татварын байгууллагад төлж байх зарчмыг баримтлан ажиллана.

19. АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ОРГИЛ РАШААН СУВИЛАЛ ТӨХК

2016 оны 12 дүгээр сарын 31 –ний өдрөөр тасалбар болсон тайлант жилийн

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(төгрөгөөр)		
БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	2015/12/31 -ний үлдэгдэл	2016/12/31 -ний үлдэгдэл
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	313,025,579	492,468,681
Татвар, НДШ -ийн авлага	1,584,594	
Бараа материал	287,263,782	341,688,647
Урьдчилж төлсөн зардал / тооцоо	50,000,000	50,000,000
Эргэлтийн хөрөнгийн дүн	651,873,955	884,157,328
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	4,503,744,095	4,272,808,482
Биет бус хөрөнгө	16,160,500	18,771,900
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,519,904,595	4,291,580,382
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,171,778,550	5,175,737,710
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	2,228,445	1,460,269
Татварын өглөг	3,519,973	4,268,876
ЭМД, НДШ -ийн өглөг		213,379
Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,748,418	5,942,524
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	5,748,418	5,942,524
ЭЗДИЙН ӨМЧ		
Өмч : - төрийн	1,446,082,516	1,446,082,516
- хувийн		
- хувьцаат		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,301,262,160	1,301,262,160
Хуримтлагдсан ашиг	2,418,685,457	2,422,450,511
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,166,030,133	5,169,795,186
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,171,778,550	5,175,737,710

ОРГИЛ РАШААН СУВИЛАЛ ТӨХК

2016 оны 12 дүгээр сарын 31 –ний өдрөөр тасалбар болсон тайлант жилийн

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)	2,825,292,394	2,726,930,021
Борлуулалтын өртөг		
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	2,825,292,394	2,726,930,021
Түрээсийн орлого	60,053,130	52,223,786
Хүүний орлого	35,199,727	14,776,618
Бусад орлого	13,353,314	17,176,726
	108,606,171	84,177,130
Борлуулалт маркетингийн зардал	33,205,464	19,009,359
Ерөнхий ба удирдлагын зардал	3,125,135,474	2,776,682,669
	3,158,340,938	2,795,692,028
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	402,329	1,120,327
Бусад ашиг (алдагдал)	(9,082,693)	(10,816,395)
	(8,680,363)	(9,696,068)
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	(233,122,736)	5,719,055
Орлогын татварын зардал	3,519,973	2,049,568
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ (АЛДАГДАЛ)	(236,642,709)	3,669,487
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(236,642,709)	3,669,487
ОРЛОГЫН НИЙТ ДҮН	(236,642,709)	3,669,487
НЭГЖ ХУВЬЦААНД НООГДОХ СУУРЬ АШИГ (АЛДАГДАЛ)		

ОРГИЛ РАШААН СУВИЛАЛ ТӨХК

2016 оны 12 дүгээр сарын 31 –ний өдрөөр тасалбар болсон тайлант жилийн

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)				
ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2014 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,446,082,516	1,301,262,160	2,915,685,242	5,663,029,918
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(16,757,076)	(16,757,076)
Залруулсан үлдэгдэл	1,446,082,516	1,301,262,160	2,898,928,166	5,646,272,841
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(236,642,709)	(236,642,709)
Бусад дэлгэрэнгүй орлого				0
Өмчид гарсан өөрчлөлт				0
Зарласан ногдол ашиг			(243,600,000)	(243,600,000)
2015 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,446,082,516	1,301,262,160	2,418,685,457	5,166,030,133
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			95,567	95,567
Залруулсан үлдэгдэл	1,446,082,516	1,301,262,160	2,418,781,024	5,166,125,699
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			3,669,487	3,669,487
2016 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	1,446,082,516	1,301,262,160	2,422,450,511	5,169,795,186

ОРГИЛ РАШААН СУВИЛАЛ ТӨХК

2016 оны 12 дүгээр сарын 31 –ний өдрөөр тасалбар болсон тайлант жилийн

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	ТАЙЛАНТ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	2,953,885,527	2,816,182,319
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,080,686,328	1,968,452,995
Эрхийн шимтгэл, хураамж төлбөрийн орлого	73,015,138	29,168,362
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	741,599,031	765,832,241
Бусад мөнгөн орлого	58,585,030	52,728,721
Мөнгөн зарлагын дүн (-)	2,980,902,262	2,602,607,634
Ажиллагсдад төлсөн	1,244,176,867	936,755,979
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	283,027,662	227,310,192
Бараа материал худалдан авахад төлсөн	737,293,094	712,212,122
Ашиглалтын зардалд төлсөн	329,016,466	418,605,323
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,999,800	13,900,000
Татварын байгууллагад төлсөн	206,203,453	188,510,541
Даатгалын төлбөрт төлсөн	994,030	800,000
Бусад мөнгөн зарлага	171,190,890	104,513,477
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(27,016,735)	213,574,685
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	0	16,101,376
Хүлээн авсан хүүний орлого		14,776,618
Бусад		1,324,757
Мөнгөн зарлагын дүн (-)	52,101,500	50,028,528
Үндсэн хөрөнгө олж, эзэмшихэд төлсөн	26,151,500	23,268,528
Биет бус хөрөнгө олж, эзэмшихэд төлсөн		8,920,000
Хөрөнгө оруулалт олж, эзэмшихэд төлсөн	25,950,000	17,840,000
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(52,101,500)	(33,927,152)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	402,329	0
Бусад	402,329	
Мөнгөн зарлагын дүн (-)	243,712,350	204,430
Төрөл бүрийн хандив	243,600,000	
Бусад	112,350	204,430
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(243,310,021)	(204,430)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(322,428,256)	179,443,102
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	635,453,835	313,025,579
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	313,025,579	492,468,681